



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/68

Улаанбаатар хот


Салбар зөвлөл шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөлмөр эрхлэлтийн дүүргийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Хөдөлмөр эрхлэлтийн талаар хууль, тогтоомж, төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны тайлан, мэдээг дүгнэж нэгтгэн танилцуулахыг Хөдөлмөр эрхлэлтийн дүүргийн салбар зөвлөлийн дарга /Ж.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Нийгмийн бодлогын хороо /Э.Ууганцэцэг/-д үүрэг болгосугай.



Б.МӨНХЦЭЦЭГ

118000226

Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын даргын 2017
оны 05 дугаар сарын 10-ны өдрийн
06 дугаар тогтоолын хавсралт

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ДҮҮРГИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДХҮҮН

Дарга:	Засаг дарга
Гишүүд:	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга
Ажилтны эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхлын төлөөлөл:	Нийслэлийн үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны Сонгинохайрхан дүүрэг хариуцсан зохион байгуулагч /зөвшилцсөнөөр/ Сонгинохайрхан дүүргийн үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны хэлтсийн дарга
Ажил олгогчийн төлөөлөл:	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны сургалт хөгжлийн хэлтсийн дарга /зөвшилцсөнөөр/ Сонгинохайрхан дүүргийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн захирал Их Засаг Их сургуулийн 2 дугаар цогцолборын захирал
Нарийн бичгийн дарга:	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн Хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга